



“ТАЛЫН МЕТАЛ НУНТАГ” ХХК

Металл боловсруулах бичил үйлдвэр

**Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний
биелэлтийн тайлан**

Улаанбаатар

2023 он



НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ
ОРЧНЫ ГАЗАРТ

16102 Улаанбаатар хот, Баянгол дүүрэг,
20-р хороо, ДСАА, 1-р гудамж, 9-гоот
Мэйл: info@smp.mn, Утас: + 976 75079900

2023.10.26 № 23/73
танай _____ № _____ т

Байгаль орчны менежментийн
төлөвлөгөөний тайлан хүргүүлэх
тухай

“Талын метал нунтаг” ХХК /РД: 6247814/ нь Төмөрлөг боловсруулах
чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд 2023 оны Байгаль орчны менежментийн
төлөвлөгөөний биелэлтийн тайланг хүргүүлж байна.

Хавсралт 40 хуудас

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Б.ЭНХБАТ

“ТАЛЫН МЕТАЛ НУНТАГ” ХХК НИЙ УЛААНБААТАР ХОТ, БАЯНГОЛ ДҮҮРЭГ,
20-Р ХОРООНЫ НУТАГТ ХЭРЭГЖИНЭ. НУТАГТ ОРШИХ “МЕТАЛЛ
БОЛОВСРУУЛАХ БИЧИЛ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН 2022ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН
ТАЙЛАН

АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6247814



ТАНИЛЦСАН:
ДАРГА

Ц. УРАНЧИМЭГ

ХЯНАСАН:

Ц. ЖАРГАЛНЭМЭХ

БИЕЛЭЛТИЙГ ТАЙЛАГНАСАН:
“ТАЛЫН МЕТАЛ НУНТАГ” ХХК
ЗАХИРАЛ
“ТАЛЫН МЕТАЛ НУНТАГ” ХХК
БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЭРГЭЖИЛТЭН



Б.АСХАР

Г.АНХБАТ

2022 ОН

БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГТ БАЙРЛАХ
“ТАЛЫН МЕТАЛ НУНТАГ” МЕТАЛЛ БОЛОВСРУУЛАХ БИЧИЛ
ҮЙЛДВЭРИЙН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛСЭН БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙН ТАЙЛАН

/АЖ АХУЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТУСГАЙ ЗӨВШӨӨРЛИЙН ДУГААР:383/

/АЖ АХУЙН НЭГЖИЙН РЕГИСТРИЙН ДУГААР: 6247814/

ХЯНАСАН:/Ж.БАТЗОЛБОО/

БОЛОВСРУУЛСАН:/АНХБАТ/
“ТАЛЫН МЕТАЛ НУНТАГ” ХХК-ИЙН ХЭМАБ-Н МЕНЕЖЕР



Гарчиг

БҮЛЭГ 1. ТУХАЙН ЖИЛИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	2
БҮЛЭГ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	3
БҮЛЭГ 3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	7
БҮЛЭГ 4. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	19
БҮЛЭГ 5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	20
БҮЛЭГ 6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ	24
БҮЛЭГ 7. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ	34
БҮЛЭГ 8. НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ ...	37

Зургийн жагсаалт

Зураг 1 Гадна тохижилтын ажил гүйцэтгэл	5
Зураг 2. Үйлдвэрийн байр хойд талаас харагдах байдал	8
Зураг 3. Үйлдвэрийн байрны баруун хойд талын харагдах байдал	8
Зураг 4. Үйлдвэрийн байр урд талаас /хайрга дэвссэн байдал/	9
Зураг 5. Талбайн баруун тал /асфальт, хайрга дэвссэн байдал/	9
Зураг 6. Ногоон байгууламж	12
Зураг 7 “Талын метал нунтаг” ХХК-ийн хамт олон	14
Зураг 8. Хог хаягдлын цэг	21

БҮЛЭГ 1. ТУХАЙН ЖИЛИЙН БИЗНЕС ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Тусгай зөвшөөрлийн нэр: “Төмөрлөг боловсруулах, машины үйлдвэрлэл эрхлэх”

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “Талын метал нунтаг” ХХК

Регистрийн дугаар, улсын бүртгэлийн дугаар: 6247814, 9011713027

Төсөл хэрэгжүүлэгч хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, 20-р хороо, ДСАА 1 гудамж, 9 тоот

Төсөл хариуцсан ажилтны нэр, утас: Г.Анхбат, 89078935

“Талын метал нунтаг” ХХК нь өөрийн хэрэгжүүлж буй металл боловсруулах бичил үйлдвэр байгуулах төсөлдөө Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3 дахь хэсэг, Байгаль орчны нөлөөллийн үнэлгээ хийх журмын 3 дугаар зүйл, холбогдох аргачлалын дагуу байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ болон нарийвчилсан үнэлгээг мэргэжлийн эрх бүхий байгууллага “ЖЭМР” ХХК-аар хийлгэсэн болно.

“Талын метал нунтаг” ХХК нь “Степпе Линк” ХХК-тай хамтран 2020 оны 3 дугаар сараас эхлэн үйлдвэрийн барилгын гадна тохижилт, зам талбайн ажлыг нийт 199,143,080 төгрөгөөр гүйцэтгүүлж бэлэн болсон.

Монголын анхны нунтаг төмөрлөгийн үйлдвэр нь 2022 оны 04 дүгээр сарын 11 өдөр нээлтээ хийсэн.

Энэхүү үйлдвэр нь ХБНГУ-ын технологийг Монгол улсад нутагшуулан катодын зэс болон хоёрдогч эх үүсвэрийн зэсийг боловсруулан нэмүү өртөг шингэсэн нунтаг металлыг үйлдвэрлэж эхлээд байна. Компани нь бүтээгдэхүүнээ экспортлохоос гадна нунтаг төмөрлөгт суурилсан орчин үеийн аж үйлдвэрийн бүтээгдэхүүнүүдийг дотоодод үйлдвэрлэхээр зорин ажиллаж байна.

Бүх төрлийн нунтаг металлд физик, химийн иж бүрэн шинжилгээ хийж гүйцэтгэх дотоод хяналтын лаборатори үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Уг лаборатори нь шинжилгээний орчин үеийн дэвшилтэт тоног төхөөрөмжүүдийг ХБНГУ болон АНУ-аас худалдан авч, суурилуулсан.

Лаборатори нь цаашид үйлдвэрийн бүтээгдэхүүн хөгжүүлэлтээс гадна автомашины жижиг эд ангийг бага хэмжээгээр үйлдвэрлэх боломжтой.

БҮЛЭГ 2. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2.1 Ус, цахилгаан, дулааны төлбөрийн мэдээлэл

Үйлдвэрийн объектууд төвийн дулааны болон цэвэр бохир усны шугам сүлжээнд холбогдож техникийн нөхцөлөө авсан бөгөөд сар бүр цахилгаан, дулаан, ус ашигласны төлбөрийг төлж байна. Үүнд:


1. Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газар: Цэвэр усаар хангах, хэрэглээнээс гарсан бохир ус татан зайлуулах гэрээ
2. УБДС ТӨХК: Нийслэлийн хотын төвлөрсөн дулаанд холбогдож дулааны эрчим хүчээр хангагдаж байна.
3. Улаанбаатар цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн баруун түгээх

[“Талын метал нунтаг” ХХК-ийн сүүлийн 12 сарын цахилгааны хэрэглээ](#)



“Талын метал нунтаг” ХХК-ийн Ус, Дулааны төлбөрийн мэдээлэл

Хэрэглээний судалгаа мөнгөн дүнгээр



Баримтын дугаар	Огноо	Үйлчилгээний нэр	Бичилт	Монгол Улсын Засгийн Газрын төлсөн дүн	Төлөлт	Нэхэмжлэх, тамгатай баримт татах
DBA27117	2023-09-30	Дулааны төлбөр тавилт	181,386.43	0.00	0.00	
0	2023-09-20	Дулааны үнэ	0.00	0.00	223,650.00	
01	2023-08-31	Гэрээний дэвтэрийн бичилт	0.00	0.00	0.00	
DBA25829	2023-08-31	Дулааны төлбөр тавилт	550.00	0.00	0.00	
01	2023-08-22	Халаалт залгалт	221,100.00	0.00	0.00	
0	2023-05-09	Дулааны үнэ	0.00	0.00	1,144,843.35	
DBA21535	2023-04-30	Дулааны төлбөр тавилт	1,144,843.35	0.00	0.00	
601	2023-04-17	Дулааны үнэ	0.00	0.00	1,418,948.78	
DBA20616	2023-03-31	Дулааны төлбөр тавилт	1,418,948.78	0.00	0.00	
271	2023-03-09	Дулааны үнэ	0.00	0.00	1,544,490.79	
DBA19815	2023-02-28	Дулааны төлбөр тавилт	1,544,490.79	0.00	0.00	
376	2023-02-14	Дулааны үнэ	0.00	0.00	2,681,361.36	
DBA19377	2023-01-31	Дулааны төлбөр тавилт	2,681,361.36	0.00	0.00	
528	2023-01-16	Дулааны үнэ	0.00	0.00	2,482,129.19	
DBA18455	2022-12-31	Дулааны төлбөр тавилт	2,482,129.19	0.00	0.00	
1558	2022-12-26	Дулааны үнэ	0.00	0.00	1,342,806.00	
DBA17206	2022-11-30	Дулааны төлбөр тавилт	1,342,805.88	0.00	0.00	
9	2022-11-09	Дулааны үнэ	0.00	0.00	829,864.93	

2.2 Хүн техникийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэхээс урьдчилан сэргийлэх

Хүн техникийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэхээс сэргийлж үйлдвэрийн гадна тохижилт, зам талбайн ажилд 279,216,424₮ төсөвлөн ажил бүрэн дууссан. Үйлдвэрийн талбайн зураг төслийн дагуу машин механизм зорчих хэсгийг хатуу хучилттай болгож, явган хүний зам талбайд зориулалтын хавтан дэвсэх ажлыг хийсэн. Мөн оффисын байрны гаднах зурвас хэсэг болон хашааны гадна талын авто зогсоолын хэсэгт ногоон байгууламж бий болгож 16 ширхэг Голт бор мод тарьсан.

Зураг 1 Гадна тохижилтын ажил гүйцэтгэл



Гадна талбайн асфальт бетоноор хучигдаагүй бүх талбайг 10/20мм голчтой хайрга дэвсэж орчны тоосжилтоос хамгаалсан.




Гадна орчны тохижилтын хүрээнд орчны тоос шорооноос хамгаалж 40x40x10см хэмжээтэй даацын эко хавтанг суурилуулсан.



Ногоон байгууламжийг нэмэгдүүлэх зорилгоор 16 Голт бор мод тарьсан.



Хүн, техникийн хөдөлгөөнөөс тоосжилт үүсэхээс сэргийлж гол тээврийн хэрэгсэл зорчих талбайг асфальтаар хучсан.



Авто замын дагуу нийтийн эзэмшлийн явган хүний зам хийж гүйцэтгэсэн бөгөөд зориулалтын явган хашааг татсан болно.

БҮЛЭГ 3. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

3.1 Үйлдвэрийн талбайн тохижилтын ажил хийгдсэн байдал

Үйлдвэрийн бүс нийт 8200 м² талбайтай бөгөөд үүнээс 2550 м² талбайг хатуу хучилттай, 4580 м² талбайд хайрга чулуу дэвсэж тоос шороо босох, хүн техникийн хөдөлгөөнөөр талхлагдахаас сэргийлсэн.

Орчны тохижилт, нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд нийтдээ 199,143,080 төгрөг зарцуулсан ба дараах ажлуудыг хийж гүйцэтгэсэн.

хучилтын ажил


Шифр	Ажлын нэр	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Дундаж зэрэг/Тариф	Нэгж хүн-цаг	Нийт хүн-цаг	Бүгд цалин	Нэмэгдэл цалин	Алслалтын нэмэгдэл	Нийт цалин
25-06-01	Халуун асфальтбетон хольцоор хучилт байгуулах (өнгө асфальт 3 см/)	1м3	39	3.3 / 5444	0.51	19.84	108031	16313	0	124343
25-06-01	Халуун асфальтбетон хольцоор хучилт байгуулах /Суурь асфальт 4 см/	1м3	52	3.3 / 5444	0.51	26.46	144041	21750	0	165791
25-05-06	Буталсан чулуун хольцыг автогрейдерээр тэгшлэж суурь байгуулах	1м3	260	3.3 / 5444	0.09	22.32	121487	18345	0	139832
25-05-02	Суурийн доод үе байгуулах /ХХҮе/	1м3	260	3.0 / 5207	0.19	48.68	253496	38278	0	291774
25-12-02	Замын хашлага тавих	1у/м	140	3.1 / 5286	0.32	44.34	234393	35393	0	269786
25-12-01	Явган хүний замын хашлага тавих	1у/м	60	3.1 / 5286	0.19	11.52	60907	9197	0	70104
25-07-20	Явган хүний замын суурийг элс-хайрганы хольцоор хийх	1м3	43.97	3.4 / 5523	0.26	11.47	63344	9565	0	72909
25-07-22	Явган хүний замын хучилтийг өнгөт хавтангаар хийх	1м2	168	3.7 / 5761	0.26	43.98	253383	38261	0	291643
26-07-19	Ус зайлуулах лотки суурилуулах	1у/м	45	3.5 / 5602	1.23	55.38	310240	46846	0	357086
25-04-66	Шороон талбайн тэгшилгээ	1м3	734.344	4.0 / 5998	0.06	45.83	274891	41509	0	316399
25-04-06	Экскаватороор хөрс ухаж шилжүүлэх	1м3	734.344	4.0 / 5998	0.06	45.83	274891	41509	0	316399
25-20-02	Тэгшилсэн шороог доргиурт индүүгээр нягтруулах	1м3	734.344	0.0 / 0	0	0	0	0	0	0
25-07-23	Гадна зогсоолын эко хавтан суурилуулах	1м2	271.7	3.5 / 5602	0.16	43.75	245067	37005	0	282073




Зураг 2. Үйлдвэрийн байр хойд талаас харагдах байдал




Зураг 3. Үйлдвэрийн байрны баруун хойд талын харагдах байдал



Зураг 4.Үйлдвэрийн байр урд талаас /хайрга дэвссэн байдал/



Зураг.5 Талбайн баруун тал /асфальт, хайрга дэвссэн байдал/





Орчны тохижилт нөхөн сэргээлтийн ажлын хүрээнд:

Галын сарайнд дутуу гал унтраах хэрэгслийг гүйцээж өнгө сэргээж будах ажил хийгдсэн.



0.4 КВ-ын агаарын дэд станцад суурь блокоор хашаа хийж орчны аюулгүй байдлыг хангасан.



Нийтийн эзэмшлийн зам талбайн зэрлэг ургамлыг тастаж зайлуулсан.



Орчны өнгө үзэмж дээшлүүлэх тохижилтын хүрээнд борооны усанд зэвэрсэн хашааг будсан.



Орчны өнгө үзэмж дээшлүүлэх тохижилтын хүрээнд борооны усанд зэвэрсэн хашааг будсан




Дулааны үзельийн ерөөний тоос, шороог арчиж цэвэрлэсэн.

3.2 Ногоон байгууламж бий болгосон байдал

Газрын тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.6-д заасны дагуу “эзэмшилд авсан газрын 10-аас доошгүй хувьд ногоон байгууламж байлгана” гэж заасны дагуу үйлдвэрийн талбайн тодорхой хэсгүүдэд тохижилтын ажил хийж, зурвас газруудад ногоон байгууламж бий болгосон.

Зураг 6. Ногоон байгууламж




Ногоон
байгууламж
нэмэгдүүлэх
ажлын хүрээнд
16 ширхэг Голт
бор мод
байршуулсан.




Оффисын
байрны зүүн
талын
зүлэгжүүлэлт.



Нийтийн эзэмшлийн зам талбайг зүлэгжүүлсэн байдал.



Оффисын байрны баруун талын зүлэгжүүлэлт.



Нийтийн эзэмшлийн зам талбайн зүлэгжүүлэлт болон зэрлэг ургамлыг зайлуулсан байдал.

3.2.1 “Тэрбум мод”

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Талын метал нунтаг” ХХК-ийн ажилчид “Баянгол цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ -ын талбайд байгуулсан төгөлд 1,000,000₮ зардлаар 30 ширхэг монос мод тарьж ирээдүй хойч үедээ үлдээх эрүүл ногоон орчныг бүтээхэд бодит хувь нэмэр орууллаа.

Зураг 7 “Талын метал нунтаг” ХХК-ийн хамт олон





Баянгол цэцэрлэгт хүрээлэн

2 days ago · 🌐



🌱 “ТЭРБУМ МОД” үндэсний хөдөлгөөнд нэгдэж, “Талын метал нунтаг” ХХК-ны төлөөлөл албан хаагчид Цэцэрлэгт хүрээлэнгийн талбайд мод тариалаа.

🌱 Нийгмийн хариуцлагын хүрээнд ирээдүй хойч үедээ үлдээх ногоон орчныг бий болгоход хөрөнгө оруулалт хийж, идэвх санаачилгатай хамрагдсан та бүхэнд талархал илэрхийлье.

[Steppe Metal Powder](#)



3.2.2 Бүх нийтийн цэвэрлэгээ



НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20 ДУГААР ХОРООНЫ ЗАСАГ ДАРГЫН АЛБАН МЭДЭГДЭЛ

Улаанбаатар хот, Баянгол дүүрэг, Энхтайваны өргөн чөлөө,
16102 Утас:70181198

2023 оны 02 сарын 15 өдөр

Улаанбаатар хот

АЖ АХУЙ НЭГЖИД МЭДЭЭЛЭЛ ХҮРГҮҮЛЭХ ТУХАЙ

Улаанбаатар хотын Ерөнхий менежерийн 2023 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/01 дүгээр тушаал, Дүүргийн Засаг даргын баталсан 2023 оны 01 дүгээр сарын 16-ны өдрийн А/16 дугаар захирамжийн дагуу 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр сар шинийн баярыг угтсан “Хоггүй шинэлье” бүх нийтийн их цэвэрлэгээний ажил зохион байгуулагдана.

Иймд хорооны нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгж байгууллага, иргэн сууц өмчлөгчдийн холбоод, ойр орчмын 50 метр хүртэлх зам талбайд цэвэрлэгээ хийж тайлан мэдээг bgdhoroo20@gmail.com цахим хаягаар 2023 оны 02 дугаар сарын 17 ны өдрийн 16 цагт ирүүлнэ үү.

ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ *[Signature]* Б.БҮРЭНЖАРГАЛ



“Талын метал нунтаг” ХХК Бүх нийтийн их цэвэрлэгээ 2023.02.17



**НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20 ДУГААР ХОРООНЫ ЗАСАГ
ДАРГЫН АЛБАН МЭДЭГДЛИЙН ХАРИУ**

Баянгол дүүргийн 20-р хороо, ДСАА-1 гудамж, 9 тоот хаягт үйл ажиллагаа эрхэлдэг “Талын метал нунтаг” ХХК 2023 оны 02 дугаар сарын 17-ны өдөр ойр орчмын 50 метр хүртэлх зам талбайд цэвэрлэгээ хийсэн тайлант мэдээг хүргүүлж байна.

Зам талбайд цэвэрлэгээ хийсэн хог хаягдлыг өөрийн хашаанд цуглуулж Баянгол шинэ өргөө ОНӨААТҮГ-тай хийсэн Хог хаягдал тээвэрлэх, хураамж төвлөрүүлэх гэрээний хүрээнд ачуулсан болно.

“Талын метал нунтаг” ХХК-ийн
ХАБЭА-н менежер

Г.Анхбат

1.	 A photograph showing several workers in winter clothing using shovels to clear snow from a paved brick path. In the background, there are utility poles, power lines, and industrial buildings under a clear blue sky.	<p>2023 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн Баянгол дүүргийн засаг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Бүрэнжаргалын ирүүлсэн мэдээллийн хүрээнд бүх нийтийн цэвэрлэгээнд хамрагдсан.</p>
2.	 A photograph of a worker in a red jacket pushing a wooden wheelbarrow filled with snow on a wide, snow-covered street. Other workers are visible in the distance, and there are cars parked on the side of the road.	<p>Үйлдвэрийн гадна орчмын хог хаягдлыг цуглуулж шуудайлан өөрийн хог хаягдлын цэг дээр бөөгнүүлсэн.</p>
3.	 A photograph showing a group of about six workers in winter gear standing on a snow-covered area. One worker is pushing a wheelbarrow. They appear to be in the middle of a snow-clearing operation. The background shows industrial buildings and utility poles.	<p>“Талын метал нунтаг” ХХК-ийн бүх нийтийн цэвэрлэгээнд хамрагдсан хамт олон.</p>

БҮЛЭГ 4. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

Төслийн үйл ажиллагааны явцад байгалийн аюул, гэнэтийн осол, эрсдэлийн нөхцөл байдлаас үүдэн гарч болзошгүй эрсдэлийг үнэлэх нь байгаль орчны нөлөөллийн үнэлгээний ажлын чухал хэсэг байдаг. Иймд эдгээр эрсдэлийг холбогдох эрх бүхий байгууллагаас батлан мөрдүүлж байгаа аргачлалын дагуу хийж, түүнээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний хүрээнд дараах ажлуудыг хийв.

4.1 Байгалийн аюул, осол эрсдэл

4.1.1 Гамшгаас хамгаалах төлөвлөгөө

Байгалийн аюул, осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх, бэлтгэл, бэлэн байдлыг хангах, аврах, хор уршгийг арилгах зорилгоор “Талын метал нунтаг” ХХК-ийн 2023 оны Гамшгаас хамгаалах төлөвлөгөөг боловсруулж Баянгол дүүргийн онцгой хэлтсийн орлогч, гамшгаас хамгаалах төлөвлөлт бэлэн байдал хариуцсан ахлах мэргэжилтэн, гамшгаас хамгаалах улсын хяналтын ахлах байцаагч С.Жанузак хянаж баталсан.

4.1.2 Гэнэтийн ослын даатгал

Бүх төрлийн гэнэтийн осол буюу урьдчилан таамаглах боломжгүй, гэнэтийн шинжтэй тохиолдлоос ажилтны амь нас эрсдэх, эрүүл мэнд хохирох, гэмтэх, бэртэх, хөдөлмөрлөх чадварт нөлөөлөх шинж бүхийн нөхцөлөөс ажилчдыг хамгаалах зорилгоор “МИГ Даатгал” ХХК-тай гэрээ байгуулж ажиллаж байна.

4.1.3 Эрүүл мэндийн үзлэг

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 44 дүгээр зүйл, 43 дугаар зүйлийн 2 дах заалт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4 дэх заалт, Засгийн газрын 2012 оны 122 дугаар тогтоолын 3.1.7 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор “Талын метал нунтаг” ХХК жил бүр Эрүүл мэндийн урьдчилсан болон хугацаат үзлэгийг Интермед эмнэлэгтэй хамтран гүйцэтгэж байна.

4.1.4 Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ

Хөдөлмөрийн сайдын 2015 оны А/223 дугаар тушаалын хавсралт болох Ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийн үнэлгээ хийх журамд үндэслэн аж ахуйн нэгж байгууллагын ажлын байрны хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, ажлын байрны орчинд нөлөөлөх хүчин зүйлийг тодорхойлох, эрсдэлт хүчин зүйлсийг илрүүлэх, газрын дор, хортой, халуун, хүнд нөхцөлийг тодорхойлон хэмжилт, судалгаа хийх, үнэлгээ өгөх, мэргэжлээс шалтгаалсан өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрүүл аюулгүй ажлын байрыг бий болгоход зориулж “Хэлт энд Сэфти Солушинс” ХХК-тай хамтран ажиллах гэрээ байгуулж 2023 оны 02 дугаар сарын 01 өдөр гүйцэтгэсэн.

БҮЛЭГ 5. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

5.1 Төлөвлөгөөний зорилго

- ✓ Хог хаягдлын менежментийн талаарх дотоодын болон олон улсын хууль, стандартуудыг тодорхойлох
- ✓ Үйлдвэрийн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлын нөлөөллийн болзошгүй эх үүсвэрүүдийг тодорхойлох
- ✓ Хог хаягдлын менежментийн үйл ажиллагааны журмуудыг тодорхойлох
- ✓ Үүрэг хариуцлагыг тодорхойлох

5.2 Хууль эрх зүйн орчин

Доор дурдсан хог хаягдлын журмууд, стандартууд нь хог хаягдлыг цуглуулах, ялгах, хадгалах, боловсруулах, зайлуулахтай холбоотой Монгол улсын хууль, дүрэм, журам стандартуудыг заасан болно.

Монгол улсын хууль журам

- ✓ Хог хаягдлын тухай Монгол улсын хуулийн зорилт нь /2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр/ хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаарх боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- ✓ Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн зорилт нь /2006 оны 5 дугаар сарын 25-ны өдөр/ Энэ хуулийн зорилт нь химийн хорт болон аюултай бодисыг экспортлох, импортлох, Монгол Улсын хилээр дамжуулан тээвэрлэх болон үйлдвэрлэх, хадгалах, худалдах, тээвэрлэх, ашиглах, устгах, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- ✓ Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам /2018 оны 5 дугаар сарын 02-ны өдөр/ нь Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлан мэдээ цуглуулах болон эдгээр үйл ажиллагаанаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, хамгаалахад энэхүү журмын зорилго оршино.

5.3 Менежментийн ерөнхий хандлага

Хог хаягдлыг уруу харсан пирамидаар загварчилж болно. Хамгийн түрүүнд авбал зохих арга хэмжээ нь багасгах, дахин ашиглах, дахин боловсруулах гэх мэтээр дараагийн авах арга хэмжээнүүд орно.

Тайлангийн хугацаанд хог хаягдлын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд 3,500,00 төгрөг зарцуулсан.

5.4 Хог хаягдлын цэг

Үйлдвэрийн талбайд хог хаягдлыг ангилан ялгах зориулалт бүхий тасалгаатай түр хадгалах цэг байгуулан ашиглаж байгаа. Үйлдвэрийн үйл ажиллагааны хог хаягдал байхгүй ба оффисын өдөр тутамд гарч буй хог хаягдлын хэмжээ бага.

Зураг 8. Хог хаягдлын цэг



5.5 Хог хаягдал ачуулах, тээвэрлэх үйл явц

“Баянгол Шинэ Өргөө” ОНӨААТҮГ-тай хийсэн Хог хаягдал тээвэрлэх, хураамж төвлөрүүлэх гэрээ нь 2022 оны 11 сарын 01-ны өдрөөс 2024 оны 11 сарын 01-ны өдөр хүртэл хүчин төгөлдөр үйлчилнэ. Баянгол дүүргийн 20-р хорооны Засаг даргатай Тохижилт цэвэрлэгээний гэрээг тус тус байгуулж тухай бүр хог хаягдлаа ачуулж байна. Мөн хог хаягдлын гэрээний дагуу улирал бүр 150,000 төгрөгийг хог ачуулах тээвэрлэх зардалд зарцуулж байна.



ХОГ ХАЯГДАЛ ТЭЭВЭРЛЭХ, ХУРААМЖ ТӨВЛӨРҮҮЛЭХ ГЭРЭЭ

20²² оны 4 сарын 01 өдөр

№ 8/526

Улаанбаатар хот

ТНХ 22/56

Нэг. Ерөнхий зүйл

Энэхүү гэрээ нь “Хог хаягдлын тухай” хууль, Татварын ерөнхий хууль, Баянгол дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчид 2017 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн 7/04 дүгээр тогтоолын хэрэгжилтийг хангах, Баянгол дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй иргэн, аж ахуйн нэгж, үйлчилгээний газруудаас хог хаягдлын хураамж төвлөрүүлэх, тэдгээрийн үйл ажиллагаанаас бий болсон хог хаягдлыг тээвэрлэхтэй холбогдон гарсан харилцааг зохицуулна.

1.1 Гэрээг

Нэг талаас: Баянгол Шинэ Өргөө ОНӨААТҮГ /цаашид тээвэрлэгч гэх/,

Нөгөө талаас: 9011713027 тоот улсын бүртгэлийн, 6247814

тоот регистрийн дугаартай, Баянгол дүүргийн 20-р хорооны нутаг дэвсгэрт

Талын метал нунтаг боловсруулах чиглэлээр Талын метал нунтаг нэртэйгээр үйл

ажиллагаа явуулдаг Т. Асхаг /цаашид хураамж төлөгч гэх/ нар

дараах нөхцөлөөр харилцан тохиролцож байгуулав.

Хоёр. Хог хаягдлын тээвэрлэгчийн эрх, үүрэг

2.1 Хог хаягдлын хураамжийн хэмжээг БГД-ийн ИТХ-ийн тэргүүлэгчдийн 7/04 дүгээр тогтоолд заасан тарифыг мөрдлөг болгон тогтооно;

2.2 Тээвэрлэгч гэрээгээр тохиролцсон хуваарийн дагуу хураамж төлөгчийн АХУЙН хог хаягдлын ачиж тээвэрлэнэ;

2.3 Тээвэрлэлт саатсанаас хог хаягдал хуримтлагдсан бол графикт зааснаас бусад цагаар нэмэгдэл хүч зохион байгуулан ачуулах арга хэмжээг авна;

2.4 Хог хаягдлыг тээвэрлэх тусгай зориулалтын, аюулгүй ажиллагааны шаардлагыг хангасан, тээврийн хэрэгсэлтэй байх;

2.5 Хураамж төлөгч тогтоосон хугацаанд хураамж төлөөгүй талаарх мэдэгдлийг Татварын хэлтэс, эрх бүхий албан тушаалтнаас ирүүлсэн тохиолдолд хог хаягдлын тээвэрлэхийг түдгэлзүүлэх, хураамж төлсний дараа тээвэрлэлтийг хэвийн үргэлжлүүлэх, гарсан хохирлыг нэхэмжлэх эрхтэй;

2.6 Хог хаягдлын хураамж төлөхийг шаардах;

3160112053

болно. Энэ тухай хураамж төлөгч талд урьдчилан мэдэгдэх бөгөөд хог хаягдал тээвэрлэлтийг нөхөж гүйцэтгэнэ.

Найм. Бусад

- 8.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга дарснаар хүчин төгөлдөр болно;
8.2 Гэрээнд тусгагдаагүй боловч нэмж оруулах, гэрээнд өөрчлөлт оруулах шаардлагатай тохиолдолд талууд хариуцан тохиролцож шийдвэрлэнэ.

Ес. Нэмэлт нөхцөл

9.1 Нийслэлийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2020 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн 32/02 дугаар тогтоолын хавсралтын хэрэгжилтийг хангах.

Арав. Нэмэлт өөрчлөлт

20 оны сарын ны өдөр талууд хариуцсан энэхүү гэрээнд дараах өөрчлөлтийг оруулав.

.....
.....
.....
.....

Арван нэг. Гэрээ байгуулсан талууд

Хог хаягдал тээвэрлэгч:

Баянгол Шинэ Өргөө ОНӨААТҮГ
-ын гэрээний мэргэжилтэн
Гарын үсэг Р.О.О.О.
Тэмдэг:
Утас: 94 7886 85

Хураамж төлөгч:

Түвшинтэн З.О.О.О.
Албан тушаалтай Т.О.О.О.
Гарын үсэг ТАЛЫН
МЕТАЛЛ НУНТАГ
ХХК
Тэмдэг:
Утас: 80117582
89078935

Хог тээвэрлэлт болон
Гэрээтэй холбоотой асуудлаар
Холбоо барих утас:
Баянгол Шинэ Өргөө ОНӨААТҮГ
Утас: 70002500

БГД-н Татварын хэлтсийн мэргэжилтэн
Утас: 88009908

БҮЛЭГ 6. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨРИЙН БИЕЛЭЛТ



“Талын метал нунтаг” ХХК



*“Металл боловсруулах бичил үйлдвэр”
төслийн*

**Байгаль Орчны Нөлөөллийн
Нарийвчилсан Үнэлгээний
нэмэлт тодотгол тайлан**

Улаанбаатар хот
2022 он

Батлав.

БОАЖЯ-ны Ерөнхий шинжээч:

Г.Энхмөнх

Хянасан:

БОАЖЯ-ны Шинжээч:

УЛААНБААТАР ХОТЫН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20-Р ХОРООНЫ НУТАГ ДЭВСГЭРТ
ХЭРЭГЖИЖ БҮЙ “МЕТАЛЛ БОЛОВСРУУЛАХ БИЧИЛ ҮЙЛДВЭР” ТӨСЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ (2022-2026 ОН)



Төсөл хэрэгжүүлэгч:
“Талын метал нунтаг” ХХК-ийн Гүйцэтгэх
захирал



Б.Асхар



БОННУнэлгээ хийж тайлан боловсруулсан:
Газар, Байгаль орчны зөвлөх “ЖЭМР” ХХК-
ийн Ерөнхий захирал



Р.Оюун

Улаанбаатар хот
2022 он



“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан
дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com

№ 23/10-05

Захиалагч: “Талын метал нунтаг” ХХК
Дээж авсан цэг: БГД 20 хороо ДСАА-1-9 тоот
Сорьц авсан огноо: 2023 оны 10 сар 02
Уст цэгийн төрөл: Дээж- 1, Үйлдвэр
Зориулалт:
Харилцах утас:
Аргын стандарт: MNS1097:1970

Катион	1 дм ³			Анион	1 дм ³		
	мг/л	мг-экв/л	мг-экв/%		мг/л	мг-экв/л	мг-экв/%
Ca ⁺⁺	65.00	3.24	64.11	CO ₃ ⁻	0.00	0.00	0.00
Mg ⁺⁺	17.00	1.40	27.64	HCO ₃ ⁻	197.00	3.23	63.83
Fe	0.00	0.00	0.00	Cl ⁻	45.00	1.27	25.10
K ⁺	1.00	0.03	0.51	SO ₄ ⁻	23.00	0.48	9.47
Na ⁺	9.00	0.39	7.74	NO ₃ ⁻	5.00	0.08	1.59
Дүн	92.00	5.06	100.00	Дүн	270.00	5.06	100.00

Анион катионуудын нийлбэр:

(Σ_{A+K} 362 мг/л

HCO₃ ийн хагасыг хассан анион,
катионуудын нийлбэр: 263.5 мг/л

Физик үзүүлэлтүүд

Өнгө: 0-өнгөгүй

Үнэр: 0-үнэргүй

Булингар: Булингаргүй

Тунгалаг: Тунгалаг

Хуурай үлдэгдэл, мг/л: 229 ppm

Ерөнхий хатуулаг: 4.64 мг-экв/л

1 бага хатуулагтай ус /

Урвалын орчин: pH- 7.45

Цахилгаан дамжуулах чадвар:

ЕС -0.559 ds/m

TDS: 279 ppm

$$M(0.36) = \frac{HCO_3 \ 64 \ Cl \ 25 \ [SO_4 \ 9]}{Ca \ 64 \ Mg \ 28 \ [Na \ 8]}$$


*Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, II төрлийн
цэцэг буюу дунд зэрэг эрдэсжилттэй, бага хатуулагтай ус.*

“Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018” –
стандартын шаардлагыг хангаж байна.

Жич: усны сорцыг шинжлүүлсэн байгууллага хувь хүн харууцан гүйцэтгэсэн болно.

ЗАДЛАН ШИНЖЛЭГЧ:

ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ



Д.ЭНХЧИМЭГ

Г.СОЛОНГО Ph.D, Дэд проф.



“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан
дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com

№ 23/10-05

Захиалагч: “Талын метал нунтаг” ХХК
Дээж авсан цэг: БГД 20 хороо ДСАА-1-9 тоот
Сорьц авсан огноо: 2023 оны 10 сар 02
Уст цэгийн төрөл: Дээж -2 оффис
Зориулалт:
Харилцах утас:
Аргын стандарт: MNS1097:1970

Катион	I дм ³			Анион	I дм ³		
	мг/л	мг-экв/л	мг-экв/%		мг/л	мг-экв/л	мг-экв/%
Ca ⁺⁺	65.00	3.24	64.11	CO ₃ ⁻	0.00	0.00	0.00
Mg ⁺⁺	17.00	1.40	27.64	HCO ₃ ⁻	197.00	3.23	63.83
Fe	0.00	0.00	0.00	Cl ⁻	45.00	1.27	25.10
K ⁺	1.00	0.03	0.51	SO ₄ ⁻	23.00	0.48	9.47
Na ⁺	9.00	0.39	7.74	NO ₃ ⁻	5.00	0.08	1.59
Дүн	92.00	5.06	100.00	Дүн	270.00	5.06	100.00

Анион катионуудын нийлбэр:

(Σ_{А+К}) 362 мг/л

HCO₃ ийн хагасыг хассан анион,
катионуудын нийлбэр: 263.5 мг/л

Физик үзүүлэлтүүд

Өнгө: 0-өнгөгүй

Үнэр: 0-үнэргүй

Буллинггар: Буллинггаргүй

Тунгалаг: Тунгалаг

Хуурай үлдэгдэл, мг/л: 229 ppm

Ерөнхий хатуулаг: 4.64 мг-экв/л

/ бага хатуулагтай ус /

Урвалын орчин: pH- 7.45

Цахилгаан дамжуулах чадвар:

EC -0.559 ds/m

TDS: 279 ppm

$$M(0.36) = \frac{HCO_3 \ 64 \ Cl \ 25 \ [SO_4 \ 9]}{Ca \ 64 \ Mg \ 28 \ [Na \ 8]}$$

*Химийн бүрэлдэхүүнээрээ Гидрокарбонатын анги, кальцийн бүлэг, II төрлийн
цэцэг буюу дунд зэрэг эрдэсжилттэй, бага хатуулагтай ус.*

“Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS0900:2018” –
стандартын шаардлагыг хангаж байна.

Жгв: усны сорьцыг шинжлүүлсэн байгууллага хувь хүн хариуцан гүйцэтгэсэн байна.

ЗАДЛАН ШИНЖЛЭГЧ:

ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ:



Д.ЭНХЧИМЭГ

Г.СОЛОНГО Ph.D, Дэд проф.



“НАРТ ШУУН КОНСАЛТИНГ” ХХК
ХӨРСНИЙ ИТГЭМЖЛЭГДСЭН ЛАБОРАТОРИ



Монгол улс, Улаанбаатар хот, Сонгино Хайрхан
дүүрэг, 19-р хороо, ҮЭГ, ЗК 17024 Ш/х 10
Утас: (976)-99176123, 99231836
E-mail: nartconsulting@gmail.com



Захиалагч: “Талын метал нунтаг” ХХК
Дээж авсан цэг: БГД 20-р хороо
Сорьц авсан огноо: 2023 оны 10 сар 04 өдөр
Шинжилгээ гарсан огноо: 10 сарын 11
Харилцах утас:

1. ХӨРСНИЙ ХИМИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

№	Дээж авсан гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, ds/m	Ялзмаг, %	СаСО ₃ , %	NO ₃ , мг/100г	Солилцох сууриуд, мг-экв/100 г		Шим тэжээлийн элементүүд, мг/100г	
								Ca ²⁺	Mg ²⁺	P ₂ O ₅	K ₂ O
Дээж 1, Хойд											
1	0-20	8.45	0.01	0.024	3.48	0.64	0.33	18	12	2.8	26
Дээж 2, Баруун											
2	0-20	7.74	0.075	0.176	1.67	1.6	0.53	17	9	2.7	20

2. ХӨРСНИЙ МЕХАНИК БҮРЭЛДЭХҮҮН

№	Дээж авсан гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Дээж 1, Хойд								
1	0-20	32.5	39.8	11.6	5.9	6.4	3.8	16.1
Дээж 2, Баруун								
2	0-20	62.0	25.7	4.0	3.1	3.0	2.2	8.3

3. ХӨРСНИЙ ЭРҮҮЛ АХУЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ДҮН, ИГР ХӨРСӨНД

№	Дээжний дугаар	Нянгийн тоо	Гэдэсний савханцрын титр (E.coli) MNS 3297:2019		Анаэробын (Cl.perfringens) MNS 3297:2019	
		Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
1	Дээж 1	6.1*10 ⁵	0.1<	1	0.1<	1
2	Дээж 2	5.9*10 ⁵	0.1<	1	0.1<	1



Нарт ШУУН Консалтинг ХХК

4. ХӨРСНИЙ ХҮНД МЕТАЛЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дээж авсан газар, Газар зүйн байршил	Дээж авсан гүн, см	Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
		мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг	мг/кг
Дээж 1, Хойд	0-20	40.0	45.9	0.0	67.1	15.2	20.2
Дээж 2, Баруун	0-20	48.0	54.2	0.0	99.3	20.4	19.3
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ, MNS 5850:2019							
Элсэрхэг хөрс		60	50	1	100	60	60
Шавранцар хөрс		100	70	1.5	150	80	100
Шаварлаг хөрс		150	100	3	300	100	150

*Харгалзах түвшин * Жич: Энэхүү шинжилгээний хариу нь тухайн цэгийн дээжэнд хамаарна

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭНИЙ АРГЫН СТАНДАРТУУД : (Хөрсний агрохимийн үзүүлэлтүүд
MNS3310:1991, MNS ISO10390, хөрсний механик бүрэлдэхүүн MNS6824:2020, Эрүүл Ахуйн
Шинжилгээний Стандарт MNS 5367:2004, MNS6341:2012, Хүнд металлуудыг -хаан дарсанд
атом шингээлтийн спектрометрээр MNS ISO 11466:2007)

ЗАДЛАН ШИНЖИЛГЭЭГ ГҮЙЦЭТГЭСЭН:  Х. УУГАНЦЭЦЭГ, ДЭНХЧИМЭГ
ХЯНАСАН ЛАБОРАТОРИЙН ЭРХЛЭГЧ:  Г. СОЛОНГО Ph.D, Дэд профессор



Нарт ШУҮН Консалтинг ХХК



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bghztl@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№	: 2023/А-294
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Талын метал нунтаг” ХХК
Сорьцын авсан хүний нэр, албан тушаал	: Б.Батхишиг агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл	: 1 агаар, 1 дуу чимээ
Сорьц авсан огноо	: 2023.10.05
Сорьцын тодорхойлолт	: БГД 20-р хороо төмөрлөг боловсруулах үйлдвэр
Шинжилгээний аргын стандарт	: MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021 MNS 5002:2000, САЗ А07-2016
Шинжилсэн огноо	: 2023.10.07
Хуудасны тоо	: 1/1
Үр дүн :	

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл		Нийт тоос /TSP/	Дуу чимээ
					мг/м ³			
1	Үйлдвэрийн хашаан дотор	X/05	12:10	0.016	0.052	0.071	35	
Агаарын чанарын техникийн ерөнхий шаардлага MNS 4585:2016 Зөвшөөрөгдөх дээд хэмжээ (20 минутын хэмжилт)				0.450	0.200	0.500	60	

Шинжилгээ гүйцэтгэсэн инженер:

Хянаж баталгаажуулсан:

Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга



Э.Оюунтуяа

Б.Бархасрагчаа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн хүрээнд үйлдвэрийн үйл ажиллагаанаас агаар, ус, хөрс үзүүлэх нөлөөллийг илрүүлэх, байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний хэрэгжилт, сөрөг нөлөөллийг бууруулах талаар авсан арга хэмжээний дүнг хянах шалгах, цаашдын үйл ажиллагааг тодотгох зорилгоор хяналт шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлж “ЖЭМР” ХХК-р дүгнэлт гаргуулсан болно.

6.1 2023 оны орчны хяналт шинжилгээний дүгнэлт

6.1.1 Хөрсөн бүрхэвч

Тайлант онд үйлдвэрийн талбайн сул чөлөөтэй хэсэгт тархсан хөрсийг төлөөлүүлэн 2 цэгт зүсэлт хийж “Нарт ШҮҮН Консалтинг” ХХК-ийн хөрсний итгэмжлэгдсэн лабораторид шинжлүүлж хөрсний агрохимийн болон ус-физикийн шинж чанарын үзүүлэлт, хүнд металл, эрүүл ахуйн үзүүлэлтийг тодорхойлуулсан.

Хөрсний агрохимийн шинж чанар

Зүсэлтийн дугаар	Дээж авсан гүн, см	pH	Давс, %	ЦДЧ, ds/m	Ялзмаг, %	CaCO ₃ , %	NO ₃ , мг/100г	Солилцох сууриуд, мг-экв/100 г		Шим тэжээлийн элементүүд, мг/100 г	
								Ca ⁺²	Mg ⁺²	P ₂ O ₅	K ₂ O
Дээж 1	0-20	8.45	0.01	0.024	3.48	0.64	0.33	18	12	2.8	26
Дээж 2	0-20	7.74	0.075	0.176	1.67	1.6	0.53	17	9	2.7	20

Хөрсний өнгөн үеийн урвалын орчин (pH) 7.74-8.45 буюу сул шүлтлэг шинжтэй, цахилгаан дамжуулах чадамж буюу хөрсний давсжилтыг илтгэгч үзүүлэлт нь 0.01-0.075 dS/m буюу бага (давсжилтгүй) агууламжтай байна. Энэ үзүүлэлт нь 2 dS/m дээш хэмжээтэй тохиолдолд давсжилттай гэж үздэг. Ялзмагийн агууламж 1.67-3.48% буюу үржил шим бага зэргийн агууламжтай. Шим тэжээлийн бодисын хангамжийн хувьд хөдөлгөөнт фосфор 2.7-2.8 мг/100 г, солилцох калийн хангамжаар 20-26 мг/100 г буюу бага зэрэг байна. Үүнээс үзвэл хөрсний үржил шимийн ерөнхий түвшин бага буюу үржил шим хангалтгүй, ядмаг хөрс байна.

Хөрсний механик бүрэлдэхүүн

Зүсэлтийн дугаар	Дээж авсан гүн, см	Механик ширхэгүүд, % ширхэгийн хэмжээ, мм						
		1-0.25	0.25-0.05	0.05-0.01	0.01-0.005	0.005-0.001	<0.001	<0.01
Дээж 1	0-20	32.5	39.8	11.6	5.9	6.4	3.8	16.1
Дээж 2	0-20	62.0	25.7	4.0	3.1	3.0	2.2	8.3

Хөрсний механик бүрэлдэхүүний хувьд элсэнцэр хэсэг зонхилсон. Элсэнцэр фракци нь ус, салхины эвдрэлд харьцангуй тэсвэр муутай, хөнгөн фракцид хамаарагддаг. Хөрсний дээд үе давхаргад элсний (2-0.05 мм) агууламж 72.3-87.7%, тоосны (0.05-0.002 мм) агууламж 4.0-11.6%, шаварлаг наангилаг хэсэг (<0.002 мм)-ийн хэмжээ 8.3-16.1% байна.

Хөрсний дээж авсан цэгүүдэд хүнд металлын агууламжийг шинжлүүлсэн ба хромын агууламж 40.0-48.0 мг/кг, хар тугалга 45.9-54.2 мг/кг, цайр 67.1-99.3 мг/кг, зэс 15.2-20.4 мг/кг, никель 19.3-20.2 мг/кг хооронд, кадми илрээгүй байна. Шинжилгээний дүнг Хөрс бохирдуулагч бодисын ЗДХ MNS 5850:2019 стандартын элсэрхэг хөрсөнд байх ёстой дээд хэмжээтэй харьцуулахад дээж 2-т хар тугалга бага зэрэг хэтэрсэн байна. Мөн

цайрын агууламж ЗДХ-с хэтрээгүй ч өндөр агууламжтай байна. Энэ нь төслийн талбай үйлдвэрийн районд, суурьшлын бүсэд байрладагтай холбоотой байж болзошгүй.

Хөрсөн дэх хүнд металлын шинжилгээний дүн

Дээжний дугаар	Дээж авсан гүн, см	Хөрсний хүнд металлын агууламж, мг/кг					
		Cr	Pb	Cd	Zn	Cu	Ni
Дээж 1	0-20	40.0	45.9	0.0	67.1	15.2	20.2
Дээж 2	0-20	48.0	54.2	0.0	99.3	20.4	19.3
Зөвшөөрөгдөх дээд хэмжээ MNS 5850:2019							
Элсэрхэг хөрс		60	50	1	100	60	60
Шавранцар хөрс		100	70	1.5	150	80	100
Шаварлаг хөрс		150	100	3	300	100	150

Дээж авсан цэгүүдийн хөрсөнд нянгийн бохирдол байгаа эсэхийг тогтоох үүднээс дээж авч шинжлүүлэхэд нянгийн тоо байх ёстой хэмжээнд, гэдэсний савханцрын титр болон анаэробын илрээгүй буюу биологийн бохирдолгүй хөрс болохыг илтгэж байна.

Хөрсөн дэх эрүүл ахуйн үзүүлэлт

Дээжний дугаар	Нянгийн тоо	Гэдэсний савханцрын титр (e.coli) mns 3297:2019		Анаэробын (ci.perfringens) mns 3297:2019	
	Шинжилгээний хариу	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг	Шинжилгээний хариу	Бохирдлын зэрэг
Дээж 1	6.1*10 ⁵	0.1<	1	0.1<	1
Дээж 2	5.9*10 ⁵	0.1<	1	0.1<	1

Дүгнэлт: Хөрсний хүнд металлын бохирдол илэрсэн тул бохирдлын тархсан хүрээ, гүн зэргийг нарийвчлан тодорхойлж, бохирдуулагч бодисыг өөртөө шингээдэг нэг наст ургамлыг бохирдолтой талбайд тарих арга хэмжээг 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлнэ.

5.1.2 Агаарын чанар

Үйлдвэрийн үйл ажиллагаанаас агаарын чанарт үзүүлж буй нөлөөллийг хянах үүднээс хашааны төв хэсэгт агаарын сорьц авч Байгаль орчны хэмжилзүйн төв лабораторид шинжлүүлсэн.

Агаарын сорьцын шинжилгээний дүн

Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл	Нийт тоос TSP	Дуу чимээ
						дБА
Үйлдвэрийн хашаан дотор	2023.10.05	12:10	0.016	0.052	0.071	35
MNS 4585:2016 (ЗДХ 20 минутын дундаж)			0.450	0.200	0.500	60

Шинжилгээний дүнгээс үзэхэд хүхэрлэг хийн агууламж 0.016 мг/м³, азотын давхар исэл 0.052 мг/м³, нийт тоос 0.071 мг/м³ буюу Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага

MNS 4585:2016 стандартын 20 минутын зөвшөөрөгдөх дээд хэмжээнд байна.

Үйлдвэрийн

технологийн процесс нь агаарт үүсч буй жижиг ширхэглэгт тоосонцор, бодисыг сорох төхөөрөмжтэй учир ойр орчимдоо сөрөг нөлөөлөл үзүүлэхгүй давуу талтай болно.

5.1.3 Усны чанар

Үйлдвэрийн технологийн процесс болон ажилчдын ахуйн хэрэглээнд ашиглаж буй төвийн шугамын уснаас дээж авч шинжлүүлэхэд гидрокарбонатын ангийн кальцийн бүлгийн 2-р төрлийн цэнгэг буюу дунд зэрэг эрдэсжилттэй, бага зэрэг хатуулагтай ус байна.

Физик үзүүлэлтийн хувьд өнгөгүй, үнэргүй, булингаргүй, тунгалаг байна. Харин химийн үзүүлэлтийн хувьд хуурай үлдэгдэл 229 ppm, ерөнхий хатуулаг 4.64 мг-экв/л буюу бага хатуулагтай, урвалын орчин 7.45 буюу сул шүлтлэг ус байна.

Усны шинжилгээний дүн

Катион	1 дм ³			Анион	1 дм ³		
	мг/л	мг-экв/л	мг-экв/%		мг/л	мг-экв/л	мг-экв/%
Үйлдвэр							
Ca ⁺⁺	65.00	3.24	64.11	CO ₃ ⁻	0.00	0.00	0.00
Mg ⁺⁺	17.00	1.40	27.64	HCO ₃ ⁻	197.00	3.23	63.83
Fe	0.00	0.00	0.00	Cl ⁻	45.00	1.27	25.10
K ⁺	1.00	0.03	0.51	SO ₄ ⁻	23.00	0.48	9.47
Na ⁺	9.00	0.39	7.74	NO ₃ ⁻	5.00	0.08	1.59
Дүн	92.00	5.06	100.00	Дүн	270.00	5.06	100.00
Оффис							
Ca ⁺⁺	65.00	3.24	64.11	CO ₃ ⁻	0.00	0.00	0.00
Mg ⁺⁺	17.00	1.40	27.64	HCO ₃ ⁻	197.00	3.23	63.83
Fe	0.00	0.00	0.00	Cl ⁻	45.00	1.27	25.10
K ⁺	1.00	0.03	0.51	SO ₄ ⁻	23.00	0.48	9.47
Na ⁺	9.00	0.39	7.74	NO ₃ ⁻	5.00	0.08	1.59
Дүн	92.00	5.06	100.00	Дүн	270.00	5.06	100.00

Шинжилгээний үр дүнгээр Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүй байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ MNS 0900:2018 стандартын шаардлагыг хангаж байна.

БҮЛЭГ 7. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

2019 онд төслийн үйл ажиллагаа эхлэхийн өмнө байгаль орчны одоогийн суурь нөхцөлийн судалгаа, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ, байгаль орчны менежментийн төлөвлөгөөг /цаашид “БОМТ” гэх/ “ЖЭМР” ХХК-аар гүйцэтгүүлж БОАЖЯ-аар баталгаажуулсан. БОМТ-г 5 жилээр боловсруулсан хэдий ч хууль эрх зүйн хүрээнд жил бүр тодотгон боловсруулж төрийн захиргааны төв байгууллагаар батлуулж, хэрэгжүүлэх үүрэгтэй байдаг. Энэхүү ажлын хүрээнд төслийн үйл ажиллагаатай уялдуулан байгаль орчныг хамгаалах чиглэлээр хийж гүйцэтгэсэн ажлаараа 2023 оны тухайн жилийн БОМТ-ний биелэлтийн тайланг боловсруулсан болно. Дурдсан ажлыг тухай бүр мэргэжлийн эрх бүхий байгууллагаар гүйцэтгүүлсэн.

Ажилчдын хөдөлмөр аюулгүй байдлыг хангаж зориулалтын хувцас хэрэгслээр хангасан.

Мөн БОМТ-ний чухал бүрэлдэхүүн хэсэг болох орчны хяналт шинжилгээний хөрс, усны шинжилгээг “НАРТ ШҮҮН КОНСАЛТИНГ” ХХК болон агаар, дуу чимээний шинжилгээг

ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИОР ТУС БҮР гүйцэтгүүлж, үр дүнг биелэлтийн тайланд тусгав.

Агаар, ус, хөрс, дуу чимээний хэмжилт судалгааны дүнгээс үзэхэд МУ-ын стандарт нормд заасан хэмжээнд буюу төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчинд сөрөг нөлөөлөл байхгүй байна. Нэг талаас Баянгол дүүргийн Цагдаагийн хоёрдугаар хэлтэстэй хамтран тухайн нутаг дэвсгэрт иргэд оршин суугчид нь амьдрахад таатай, аюулгүй амар тайван орчин бүрдүүлэхэд чиглэсэн гадна талын хяналтын 15 камер суурилуулсан болно.

Монгол улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд “Талын метал нунтаг” ХХК-ийн ажилчид “Баянгол цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ -ын талбайд байгуулсан төгөлд 1,000,000₮ зардлаар 30 ширхэг монос мод тарьж ирээдүй хойч үедээ үлдээх эрүүл ногоон орчныг бүтээхэд бодит хувь нэмэр орууллаа.

2023 оны 8 дугаар сарын 12 өдөр Баянгол Дүүргийн Засаг даргын А/352 дугаар захирамжийн дагуу бүх нийтийн цэвэрлэгээнд оролцож хог хаягдал болон шарилж лууль зэргийг цэвэрлэж, зурагт тайланг илгээсэн болно.

“Талын метал нунтаг” ХХК-ийн 2023 оны Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний биелэлт.

Гал болон болзошгүй сөрөг нөлөөлөл	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Тайлбар	Нийт зардал
SO ₂ , NO ₂ , нийт тоосны хэмжээ стандартаас хэтрэх	Бохир хий сорох төхөөрөмж байршуулах, ажилчдыг сургалтад хамруулах	Үйлдвэрт хоёр ширхэг процессын утааг сорж цэвэрлэх төхөөрөмж байршуулсан.	Үйл ажиллагааны зардлаар
Техникийн аюулгүй ажиллагааг мөрдөхгүйгээс үүсэх сөрөг нөлөөлөл			
Зам талбайгаас тоосжилт үүсэх	Гадна талбайг зүлэгжүүлэх, услах	Үйлдвэрийн гадна тохижилтын ажил бүрэн хийгдсэн.	Үйл ажиллагааны зардлаар
Машин техникийн утааг	Сэрээт өргөгч зэрэг машин техникийг тогтмол үзлэгт оруулах	“Юнитра” ХХК техникийн үзлэг хийсэн.	Үйл ажиллагааны зардлаар
Хийн хаягдлыг сорох төхөөрөмжийн фильтр муудах	Фильтрийг сорох төхөөрөмжийн горимын дагуу солих	Үйлдвэр 2022.04.11 сард ашиглалтад орсон солих хугацаа дуусаагүй.	Үйл ажиллагааны зардлаар
Ажилчдад физик бохирдлын улмаас эрүүл мэндийн сөрөг нөлөөлөл үүсэх	Ажилчдыг эрүүл ахуй, хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах	Интермед эрүүл мэндийн үзлэг хүний 590,000₮	6,490,000₮
	Амьсгал, гар болон нүд хамгаалах хөдөлмөрийн аюулгүй байдлын хэрэгслүүд.	“Мега сэлбэг” ХХК	759,550₮
	Ажлын өвлийн хувцас, гутал хамгаалах хэрэгсэл	“Шүрэн Элс” ХХК	1,575,000₮
	Ажлын гутал, цамц	“Würth Mongolia” ХХК	2,799,500₮
Ахуйн хог хаягдлаас үүсэх бохирдлын сөрөг нөлөөлөл	Ахуйн хаягдлыг гэрээт байгууллагаар зориулалтын цэгт хүргэж устгуулна. Ангиан ялгалт хийсэн дахивар бүтээгдэхүүнийг зохих газарт нь худалдаж борлуулна.	Баянгол шинэ өргөө ОНӨААТҮГ: Хог хаягдал тэвэрлэх хураамж төвлөрүүлэх гэрээ	600,000₮
Ажлын талбайд тэвэрийн хэрэгслээс тос масло асгарах, гоожих зэргээс хөрс бохирдох	Элс, даавуунд шингээх, spill kit ашиглаж хөрсийг саармагжуулж цэвэрлэх хэрэгслийг талбайд байршуулна	Байршуулсан	Үйл ажиллагааны зардлаар
Төвийн шугамд холбогдсон шугам хоолойн эвдрэлд гэмтэл гарах	Төвийн шугамд холбогдсон шугам хоолойд хяналт тавьж, эвдрэл гэмтлийг тухай бүх засварлах	Гэмтэлгүй	Үйл ажиллагааны зардлаар
Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны улмаас ус бохирдуулах	Үйлдвэрлэлийн бохирдсон усыг нэг бүр нь 7000 литрийн багтаамжтай ус тунгаан цэвэршүүлэх гурван дамжлагат төхөөрөмжөөр цэвэрлэж дахин ашигладаг. Төвийн бохир усны хоолойд үйлдвэрлэлийн ус	Үйлдвэрлэлийн үйл ажиллагаанаас хаягдал бохир ус хүрээлэн буй орчинд нөлөөлөхгүй.	Үйл ажиллагааны зардлаар

	нийлэхгүй, зөвхөн ахуйн хаягдал үүснэ.		
Тоосжилтын сөрөг нөлөөлөл	Ногоон байгууламжийн төлөвлөгөөний дагуу олон наст ургамал, мод сөөг, бутлаг ургамал тарих, талбайн хөрсийг бордох, үржил шимийг нэмэгдүүлэх	Тэр бум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд “Баянгол цэцэрлэгт хүрээлэн” ОНӨТҮГ 30 ширхэг монос мод тарьсан	1,000,000₮
Тоосжилтын сөрөг нөлөөлөл	Үйл ажиллагаа явуулж буй газрынхаа 10-аас доошгүй хувьд ногоон байгууламж бий болгох	16 ширхэг Голт бор мод тарьсан	Үйл ажиллагааны зардлаар
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	Байгаль орчны зөвлөгөө өгөх үйлчилгээ “ЖЭМР” ХХК	2022 онд Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэмэлт тодотгол тайлан	1,745,700₮
			2,327,600₮
	“НАРТ ШУҮН КОНСАЛТИНГ” ХХК	Үйлдвэрийн орчны хяналт шинжилгээ	216,000₮
2023 онд хэрэгжүүлсэн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал			17,513,350₮

БҮЛЭГ 8. НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ



БАЯНГОЛ ДҮҮРГИЙН 20 ДУГААР ХОРООНЫ ЗАСАГ ДАРГА

Энхтайваны өргөн чөлөө, 20 дугаар хороо,
Баянгол дүүрэг, Улаанбаатар хот, 16102
Утас: (976) 7018 1198
Цахим шуудан: bgd_20@bgd.ub.gov.mn
Цахим хуудас: www.bgd.mn

2023.10.31 № 33
танай _____-ны № _____-г

НИЙСЛЭЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ ГАЗАРТ

“Талын метал нунтаг” ХХК (РД: 6247814) нь тус хорооны нутаг дэвсгэрт “Металл боловсруулах бичил үйлдвэр” төсөл хэрэгжүүлж байгаа болно.

Уг төслийн 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайланг тус хорооны иргэний танхимд хорооны Засаг дарга, хэсгийн ахлагчид, төслийн нөлөөллийн бүсэд хамаарагдах иргэд, хорооны иргэдийн Нийтийн Хурлын үйл ажиллагаа олон нийттэй харилцах ажилтан нарыг оролцуулан танилцуулсан болно.

ЗАСАГ ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ БҮРЭНЖАРГАЛ



4160200032

1.		<p>2023 оны 02 дугаар сарын 15-ний өдрийн Баянгол дүүргийн засаг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Бүрэнжаргалын ирүүлсэн мэдээллийн хүрээнд бүх нийтийн цэвэрлэгээнд хамрагдсан.</p>
2.		<p>Үйлдвэрийн гадна орчмын хог хаягдлыг цуглуулж шуудайлан өөрийн хог хаягдлын цэг дээр бөөгнүүлсэн.</p>
3.		<p>“Талын метал нунтаг” ХХК-ийн бүх нийтийн цэвэрлэгээнд хамрагдсан хамт олон.</p>